



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар Б/78

Ховд

**Б.Маралмааг гэрээт
ажилтнаар түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт ажилтан Т.Наранчимэг нь жирэмсний болон амаржсаны амралтаа авсан тул Б.Маралмааг 2021 оны 10 дугаар сарын 18-наас 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл түр томилсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Б.Маралмааг 456172 төгрөг (дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун далан хоёр)-өөр цалинжуулж, ур чадварын нэмэгдлийг 25 хувь, унааны зардлыг өдрийн 5000 төгрөгөөр тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд нягтлан бодогч (Б.Энхмандал)-т зөвшөөрсүгэй.


4. Б.Маралмааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга (С.Батдорж)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны
өдрийн Б/78 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: С.Батдорж - Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Гишүүд: Х.Болормаа - Санхүү, аж ахуйн тасгийн нярав

Нарийн бичгийн

дарга: Ш.Дэлгэрмаа - Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт ажилтан

-ооо-